



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№51 /495/

2023.03.28

Цаг үе, үйл явдал

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 342 ДУГААР АНГИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ



Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс" баримт бичиг, батлан хамгаалахын багц хуулиудад туссан мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг Зэвсэгт хүчинтэй болох стратегийн зорилт амжилттай хэрэгжиж байна.

Энэ хүрээнд 2020 онд УИХ-ын чуулганаар Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Зэвсэгт хүчин нь шинээр Барилга-инженерийн, Кибер аюулгүй байдлын болон Тусгай хүчний цэрэгтэй байхаар хуульчлан тэдгээрийн цэргийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Энэхүү үйл ажиллагааны үргэлжлэл болж өнөөдөр Барилга-инженер, экологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий цэргийн анги Архангай аймагт байгуулагдаж буй бөгөөд ангийн бүтээн байгуулалтыг эхлүүллээ.

Уг арга хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Төсвийн байнгын хорооны дарга, УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба, Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дарга хурандаа Х.Батсайхан, Архангай аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид болон бусад албаныхан, Зэвсэгт хүчний 342 дугаар ангийн бие бүрэлдэхүүн, нутгийн иргэдийн төлөөлөл оролцлоо.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр тус ёслолын үйл ажиллагааг нээж хэлсэн үгэндээ "Тус анги нь Засгийн газрын шийдвэрээр 2015 онд албан ёсоор байгуулагдсан ч төсөв хөрөнгийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалж өнөөдрийг хүртэл бүтээн байгуулалтын ажил хийгдээгүй байсан.

Тэгвэл 2021 онд ЗХЖШ-ын даргын тушаалаар Зэвсэгт хүчний 342 дугаар ангийн бүтэц, орон тоог баталж, албан тушаалтнуудыг томилон ажиллуулж, энэ онд тодорхой хөрөнгийн асуудлыг шийдвэрлэснээр бүтээн байгуулалтын ажлыг ийнхүү эхлүүлж байна. Тус анги нь байгуулагдсан цагаасаа хойш Тавантолгой-Зүүнбаян, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам, Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам зэрэг улс орны стратегийн томоохон бүтээн байгуулалтын ажилд амжилттай оролцож ирснийг энд дуулгахад таатай байна. Зэвсэгт хүчний 342 дугаар ангийн хотхоныг Зэвсэгт хүчний хэмжээнд хэрэгжүүлж байгаа "Жишиг хотхон"-ны стандартын дагуу ангийн байрлал, тавиулан, үйлдвэрлэлийн район, албан тушаалтнуудын орон сууцны хотхон гэсэн үндсэн байгууламжтайгаар барих болно. Өнөөгийн байдлаар тус ангийн төв шалган нэвтрүүлэх байр, 1948 метрийн урттай гадна хашаа, техник шалган нэвтрүүлэх байр, гүний худаг гаргах зэрэг ажлыг бүрэн хийж дуусгасан бол энэ онд цэргийн байр, цэргийн гал тогоо, уурын зуухны барилга угсралтын ажил болон гадна цахилгаан, дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөдөг байна. Ийнхүү Архангай аймагт Зэвсэгт хүчний анги байгуулагдаж, өнөөдөр ангийн барилгын шавыг тавьж байгаа нь улс орны аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд газар зүйн байршлын хувьд стратегийн чухал ач холбогдолтой бааз суурь болохоос гадна аймаг орон нутгийн төдийгүй төвийн бүсийн хөгжлийн зорилтыг хангахад жинтэй

хувь нэмэр оруулах нь гарцаагүй. Түүнчлэн орон нутгийг дэмжих төр засгийн бодлого, зорилт биелэгдэх, алба хаагчдын ая тухтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх, орон нутагт ажлын байр шинээр бий болох, хүний нөөцөө аймаг, орон нутгаасаа бүрдүүлэх, тэднийг сургаж хөгжүүлэх, амьжиргаа, орлого нэмэгдэх, улмаар орон нутгийн хөгжил, цэцэглэлт, бүтээн байгуулалтад оролцох зэрэг бүхий л талын чухал ач холбогдолтой юм. Цаашид Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабаас тус ангийг бэхжүүлэх, үйл ажиллагаагаа явуулах төсөв, санхүүгийн болоод бусад орчин нөхцөлийг бий болгох, хүний нөөцийг бэлтгэх, зэвсэг, цэргийн техник, материал хэрэгслээр хангах зэрэг асуудлыг бодлогын түвшинд шийдвэрлэн, дэмжлэг үзүүлэн ажиллах болно. Мөн Зэвсэгт хүчний 342 дугаар ангийн офицер, ахлагчийн албан тушаалд нутгийн иргэдийг сонгон шалгаруулж авах, туршилтын хугацаанд ажиллаж байгаа бүрэлдэхүүнийг Үндэсний батлан хамгаалахын их сургуульд цэргийн анхан шатны мэдлэг, дадлага олгож, албан үүрэгт нь сургах, бие бялдар, сэтгэл зүйн хувьд бэлтгэх сургалтыг зохион байгуулна. Тус ангийн бие бүрэлдэхүүн цаашид хуулиар хүлээсэн болон төр засгаас даалгасан үүргийг амжилттай хэрэгжүүлэхийн зэрэгцээ улсыг хөгжүүлэх стратегийн томоохон бүтээн байгуулалт болон орон нутгийнхаа хөгжил дэвшилд манлайлан оролцоно гэдэгт сайдын хувьд би итгэлтэй байна" хэмээгээд хүндэт зочид төлөөлөгчид, ангийн бие бүрэлдэхүүнд зориулан ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөв.

Дэслэгч Т.ИДЭР

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
12	-8

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40	27

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,522	3,526
EUR	3,800	3,830
CNY	517	519
RUB	45.20	45.80
JPY	27	27.20
KRW	2.72	2.75

ЗУРХАЙ



ХАВРЫН ДҮНД ХӨХӨГЧИН ТУУЛАЙ САР НЭГ ЦАГААН ХӨХӨГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал:
Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
06.40-19.15
Барилдлага:
Хүчин төгсөх
ШҮТЭН БАРИЛДАГА:
Шороо

Тухайн өдөр үхэр, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, хагалгаа хийлгэх, буг дарах, газрын ам бооход сайн.

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА



БШУЯ-ны ШУТС-ийн захирал, доктор (Ph.D.) Д.Одгэрэл энэ сарын 24-ний өдөр Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнд ажиллаж, үйл ажиллагаатай нь танилцлаа. Уг арга хэмжээний үеэр ШУТС-ийн захирал Д.Одгэрэл БХЭШХ-ийн танилцуулга, судалгаа хөгжүүлэлтийн ажлын бүтээлийн үзэсгэлэн, ҮБХИС-ийн музей, буудлагын сургуулийн байртай танилцан эрдэмтэн, судлаачидтай уулзаж санал бодлоо солилцлоо. "Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологи, инновацын үр дүнгээр үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх" эрхэм зорилготой тус хүрээлэн нь шинжлэх ухаан технологийн сангийн дэмжлэгтэйгээр судалгааны ажлуудыг амжилттай хэрэгжүүлсээр ирсэнд БШУЯ-ны ШУТС-ийн захирал, доктор (Ph.D.) Д.Одгэрэл талархал илэрхийллээ. Талууд цаашид салбарын шинжлэх ухаан технологийн бодлого, судалгаа хөгжүүлэлтийн ажилд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй хамтран ажиллахаар тохиролцов.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 683,335,441

Эдгэрсэн

Нийт: 656,274,354

Нас барсан

Нийт: 6,827,102

Цахим шууданд

"МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР"-ИЙГ ТОХИОЛДУУЛАН...



Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-ийг тохиолдуулан орон нутгийн удирдлага, байгууллагуудтай хамтран Батлан хамгаалах хууль тогтоомж, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, өсвөр үеийнхэнд цэрэг-эх оронч үндэсний үзэл төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгууллаа.

Уг арга хэмжээний хүрээнд Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын дунд "Мөрдөстэй бүсгүйчүүд", "Буудлага", "Хайрлан дуулах эх орон", "Волейбол", "Сагсан бөмбөг", "Марш тактик тусгай

бэлтгэлийн аварга тасаг" шалгаруулах цэрэг-спортын олон төрөлт тэмцээнийг зохион байгуулсан бол Ерөнхий боловсролын сургуулиудын 7-12 дугаар ангийн сурагчдын дунд "Монгол Улсын Зэвсэгт хүчин", сэдвээр гар зургийн, "Монгол цэрэг-Дэлхийн цэрэг" сэдвээр эсээ бичлэгийн уралдааныг тус тус зохион явууллаа.

Тэгвэл цэрэг спортын цогцолбор тэмцээний нийлбэр дүнгээр тэргүүн байрт дэд хурандаа Н.Баяржаргал захирагчтай Хилийн цэргийн 0101 дүгээр анги, Дэд байрт хурандаа Д.Мөнбиш захирагчтай Хилийн цэргийн 0243 дугаар анги, Гутгаар байрт хурандаа Г.Галбадрах даргатай аймгийн Онцгой байдлын

газар тус тус шалгарч мөрдөс нэгт нөхдөө манлайлсан юм.

Харин сурагчдын дунд зохион байгуулсан гар зургийн болон эсээ бичлэгийн уралдаанд тэргүүн байрт Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 9а ангийн сурагч Э.Тэргэл, Дэд байрт Сайхан сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 7г ангийн сурагч Д.Энхнаран, Гутгаар байрт Сүхбаатар сумын ерөнхий боловсролын лаборатори дөрөвдүгээр сургуулийн 8а ангийн сурагч Э.Амин-Эрдэнэ нарын бүтээлүүд шилдгээр шалгарлаа.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ

"МАРШ ТАКТИКИЙН АВАРГА ТАСАГ" ШАЛГАРУУЛЛАА



"Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 102 жилийн ойг тохиолдуулан аймгийн Засаг даргын нэрэмжит цэргийн хүрээний Төрийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын дунд "Марш тактикийн аварга

тасаг" шалгаруулах тэмцээнийг Өвөрхангай аймгийн Арвайхээр сум, Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн сургуулийн төвийн районд тус тус зохион байгууллаа.

Тэмцээнд Зэвсэгт хүчний 256 дугаар анги, 113 дугаар тусгай салбар, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн газар, Тагнуулын хэлтэс, Шүүхийн шинжилгээний хэлтсийн нийт 7 тасгийн баг тамирчид эр зориг, тэсвэр хатуужил, хурд, хүч авхаалж самбаагаа сорин оролцсоноос нийлбэр дүнгээр "Тэргүүн" байрт Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн ахлагч М.Энхбат захирагчтай байнгын бүрэлдэхүүний тасаг, дэд байрт дэслэгч Ц.Ганбаатар захирагчтай цэргийн гэрээт алба хаагчдын тасаг, гутгаар байрт Онцгой байдлын газрын дэслэгч Г.Сүрэнжав захирагчтай тасаг тус тус шалгарч, аймгийн Засаг даргын нэрэмжит шилжин явах Цом, "Өргөмжлөл", мөнгөн шагналаар эзэд болцгоосон юм

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ ДЭД ХУРАНДАА Ч.АДЪЯА

"ЭХ ОРОН ТАНАА" ЦЭРГИЙН ДУУ ДУУЛААЧДЫН АЙМГИЙН 8 ДУГААР УРАЛДААН БОЛЛОО



Өвөрхангай аймгийн иргэд, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, эх орон, газар нутгаа дээдлэх үзлийг төрүүлэх зорилгоор иргэд, олон нийтийн болон Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын дунд "Эх орон танаа" цэргийн дуу дуулаачдын аймгийн 8 дугаар уралдааныг аймгийн Цэргийн штаб, Соёл урлагийн газар, Хайрхандулаан сумын Соёлын төвтэй хамтран амжилттай зохион байгууллаа.

Тус уралдаанд аймаг, сумдын ардын авьяастан дуучид болон Зэвсэгт хүчний 256 дугаар анги, 113 тусгай салбар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын нийт 25 дуучид авьяас чадвараа сорин оролцож, цэргийн

дууны төрлөөр 2 үе шаттайгаар өрсөлдлөө.

Уралдааны тэргүүн байрт Арвайхээр сумын 14 дүгээр цэцэрлэгийн багш Д.Ундрахжаргал, дэд байрт Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн багш Б.Болормаа, гутгаар байрт Бүрд сумын ардын авьяастан Ц.Даваадорж, Онцгой байдлын газрын ахлах ахлагч Э.Туул, Хужирт сумын ардын авьяастан Л.Отгонбат нар тус тус шалгарч, дуулах ур чадвар, цэргийн дууны дэг жаяг, хэмнэлийг үзэгч түмэнд батлан харуулж, өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйлийн эзэд болцгоолоо.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ ДЭД ХУРАНДАА Ч.АДЪЯА



МӨРДЭСТЭЙ БҮСГҮЙЧҮҮД ӨРСӨЛДЛӨӨ



Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрын бэлтгэлжилтийг нэмэгдүүлэх зорилгоор Хөвсгөл аймаг дахь Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын эмэгтэй алба хаагчдын дунд "Мөрдөстэй бүсгүйчүүд" уралдаан зохион байгуулав.

Тэмцээнд 300 гаруй баг, тамирчид сагсан бөмбөг, волейбол, цэрэгжлийн буухиа, үндэсний бөх, шатар зэрэг 5 төрлөөр хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс багийн нийт дүнгээр тэргүүн байрт хурандаа Ё.Пүрэвсүрэн захирагчтай Онцгой байдлын газар, дэд байрт хурандаа Б.Баасансүрэн захирагчтай Хилийн цэргийн 0257 дугаар анги, гутгаар байрт хурандаа Б.Эрдэнэбат захирагчтай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын баг тамирчид тус тус шалгарлаа.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ

ОНОЛ ПРАКТИКИЙН БАГА ХУРЛААР...



Зэвсэгт хүчний 015 дугаар анги 2023 оны сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу онол практикийн бага хурлыг амжилттай зохион байгууллаа.

Тус хуралд ЗХЖШ-ын МТГ-ын орлогч дарга, штабын дарга хурандаа Ц.Батсайхан, ЗХЖШ-ын пуужин артиллерийн зэвсэглэлийн хэлтсийн дарга хурандаа П.Чинзориг, Зэвсгийн холбооны тэргүүн бэлтгэл хурандаа Д.Батболд, Бэлтгэл хурандаа С.Эрдэнэбаатар, ЗХЖШ-ын пуужин артиллерийн зэвсэглэлийн хэлтсийн ерөнхий инженер, зэвсэг галт хэрэглэл төлөвлөлт зохицуулалтын ахлах мэргэжилтэн хошууч Энхмагнай болон ангийн нийт офицер ахлагч, ажилтан алба хаагчид оролцлоо.

Хурлаар "Пуужинт артиллерийн зэвсэглэлийн хөгжил, цаашдын чиг хандлага" сэдвээр Захирагчийн сургалт бэлтгэл

хариуцсан орлогч дэд хурандаа Э.Хадбаатар, "Орос украины дайнд пуужинт артиллерийн зэвсэглэлийг үр дүнтэй ашиглаж буй туршлага сургамж" сэдвээр ЗХЖШ-ын ахлах мэргэжилтэн хошууч Б.Энхмагнай, "Суурин ба хөдөлгөөнт зэвсэг засварын бүлгийн боломж, түүнийг дээшлүүлэх арга зам" сэдвээр Зэвсэг засварын төвийн дарга хошууч Ж.Гантогтох, "Хугацаат цэргийн алба хаагчдын сургалтаар зэвсгийн мэргэжилтэн бэлтгэх, арга зүйг боловсронгуй болгох" сэдвээр Зэвсгийн төв агуулахын дарга хошууч Б.Одсүрэн, "Буудлагын зэвсгийг сайжруулах арга зам" сэдвээр Галт хэрэглэлийн төв агуулахын галт хэрэглэлийн инженер Б.Сумьяабазар тус тус илтгэл танилцуулж төгсгөлд нь нийт бие бүрэлдэхүүний дунд нэгдсэн хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Дэслэгч Б.ЗОЛЗАЯА

